

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/318/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1 ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НД	Нийгмийн даатгал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэл осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

**ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Г.БАТСАЙХАН ТАНАА**

2024.01.25 № 4/119
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян сумын ерөнхий боловсролын сургууль 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 сарын 21-ны өдрийн 241 тоот тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” гэж заасны дагуу албан хаагчдын цалингийн хэмжээ, төсвийн төлөвлөлтөнд өөрчлөлт орсон байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Тайлант онд хандиваар 126,382.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

019020214

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	116,005,804.78	162,306,030.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	73,775,479.44	115,313,788.59
312	Банканд байгаа бэлэн мөнгө	73,775,479.44	115,313,788.59
3121	Төгрөг	73,775,479.44	115,313,788.59
31	Төрийн сангийн харилцах	73,775,479.44	115,313,788.59
33	АВЛАГА	48,648.34	
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	48,648.34	
35	БАРАА МАТЕРИАЛ	42,181,677.00	46,992,242.00
351	Түүхий эд материал	580,000.00	580,000.00
35110	Тусгай зориулалттай материал	580,000.00	580,000.00
354	Хангамжийн материал	41,601,677.00	46,412,242.00
35410	Бичиг хэргийн материал	345,800.00	345,800.00
35420	Аж ахуйн материал	12,678,410.00	16,014,825.00
35460	Хүнсний материал	1,511,750.00	2,710,400.00
35470	Бусад хангамжийн материал	27,065,717.00	27,341,217.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,773,039,145.81	1,832,053,087.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,773,039,145.81	1,832,053,087.27
392	Биет хөрөнгө	1,730,155,145.81	1,789,169,087.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,574,368,582.00	1,603,294,882.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(160,819,580.24)	(202,095,545.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,450,000.00	6,450,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,450,000.00)	(6,450,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж	169,729,793.00	246,443,793.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,925,562.21)	(80,893,764.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,393,342.65	86,419,642.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,614,224.69)	(23,115,926.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	159,940,053.00	197,938,763.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(34,178,333.22)	(49,835,273.67)
39217	Номын фонд	8,261,075.52	11,012,516.52
393	Биет бус хөрөнгө	42,884,000.00	42,884,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	42,884,000.00	42,884,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,889,044,950.59	1,994,359,117.86
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,889,044,950.59	1,994,359,117.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,889,044,950.59	1,994,359,117.86
51	Засгийн газрын хувь оролцоо	1,889,044,950.59	1,994,359,117.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	242,035,023.90	242,035,023.90
51101	Өмч:-төрийн	242,035,023.90	242,035,023.90
512	Хуримтлагдсан үр дүн	1,047,345,580.94	1,152,659,748.21
51210	Өмнөх үеийн үр дүн	1,047,345,580.94	1,047,345,580.94
51220	Тайлант үеийн үр дүн		105,314,167.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	599,664,345.75	599,664,345.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,889,044,950.59	1,994,359,117.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,868,618,314.68	1,187,881,714.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,857,352,914.68	127,759,914.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,857,352,914.68	127,759,914.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,413,000.00	1,377,548.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,413,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,377,548.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,809,470,597.66	122,133,951.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	45,469,317.02	4,248,415.00
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	278,442,900.00	1,060,121,800.00
	Улсын төвлөрсөн төсвөөс		866,887,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		866,887,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	732,822,500.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,133,600.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	88,133,600.00	
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	190,309,300.00	193,234,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт \орон нутаг\	190,309,300.00	193,234,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	979,223,151.54	1,082,567,546.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	979,223,151.54	1,082,567,546.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	880,906,944.49	1,027,343,948.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,717,152.41	618,667,424.02
210101	Үндсэн цалин	391,226,457.76	450,767,846.71
210102	Нэмэгдэл	114,972,043.71	142,974,122.24
210103	Урамшуулал	22,518,650.94	24,925,455.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,552,564.41	77,495,733.67
210201	Тэтгэврийн даатгал	44,927,788.61	53,427,370.99
210202	Тэтгэмжийн даатгал	5,273,199.25	6,206,341.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,215,199.21	4,947,473.12
210204	Ажилгүйдлийн даатгал	1,002,852.42	1,166,145.47
210205	Эрүүл мэндийн даатгал	10,133,524.92	11,748,402.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	151,227,836.00	180,773,671.54
210301	Гэрэл, цахилгаан	7,539,669.00	11,057,769.94
210302	Түлш, халаалт	143,688,167.00	169,044,901.60
210303	Цэвэр, бохир ус		671,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	530,100.00	2,017,550.00
210401	Бичиг хэрэг	505,500.00	773,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,244,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,600.00	
2105	Норматив зардал	19,129,070.00	25,007,019.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,000.00	
210502	Хоол, хүнс	19,079,070.00	24,857,019.50

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	999,590.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	999,590.00
2107	Томилолт, зочны зардал		274,000.00
210702	Дотоод албан томилолт		274,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,511,500.00	7,419,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,206,500.00	2,521,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		720,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал	1,305,000.00	4,177,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,238,721.67	114,689,759.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,874,610.02	12,661,950.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	12,996,510.00	8,625,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80,367,601.65	93,402,809.54
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,316,207.05	55,223,598.46
	Бусад урсгал шилжүүлэг	98,110,422.00	43,762,360.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж	38,254,822.00	36,794,960.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,844,900.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан	34,010,700.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,967,400.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	205,785.05	11,461,238.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,889,395,163.14	105,314,167.27
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	147,150.20	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	147,150.20	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(147.150.20)	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,889,248,012.94	105,314,167.27

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,012,471,900.00	1,061,499,348.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,206,500.00	1,377,548.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,206,500.00	1,377,548.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,206,500.00	1,377,548.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,206,500.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,377,548.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,011,265,400.00	1,060,121,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		866,887,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		866,887,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	732,822,500.00	
	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,133,600.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	88,133,600.00	
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	190,309,300.00	193,234,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт \орон нутаг\	190,309,300.00	193,234,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	938,696,420.56	989,678,238.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	938,696,420.56	989,678,238.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	847,482,363.51	933,615,798.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,856,617.05	618,667,424.02
210101	Үндсэн цалин	391,365,922.14	424,253,438.93
210102	Нэмэгдэл	114,972,043.62	169,821,102.67
210104	Урамшуулал	22,518,651.29	24,592,882.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,664,810.46	77,447,085.33
210201	Тэтгэврийн даатгал	45,089,159.15	53,187,980.06
210202	Тэтгэмжийн даатгал	5,498,050.53	6,182,766.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,999,316.53	4,908,973.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,007,280.32	1,173,217.72
210205	Эрүүл мэндийн даатгал	10,071,003.93	11,994,147.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	151,520,336.00	180,773,671.54
210301	Гэрэл, цахилгаан	7,539,669.00	9,419,890.16
210302	Түлш, халаалт	143,688,167.00	170,682,781.38
210303	Цэвэр, бохир ус	292,500.00	671,000.00
	Нормативд зардал	27,015,340.00	25,216,827.50
210502	Хоол, хүнс	27,015,340.00	25,216,827.50
	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	999,590.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	999,590.00

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,615,000.00	7,036,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,433,400.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	5,615,000.00	4,602,800.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	67,810,260.00	23,475,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,110,750.00	15,454,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,699,510.00	8,020,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,214,057.05	56,062,440.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,008,272.00	44,601,202.00
	Төрөөс иргэдэд иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	31,152,672.00	37,633,802.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,844,900.00	
	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан	34,010,700.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,967,400.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	205,785.05	11,461,238.46
	Төвлөрүүлэх шилжүүлэг	205,785.05	11,461,238.46
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	73,775,479.44	71,821,109.15
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		30,282,800.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		30,282,800.00
	Дотоод эх үүсвэрээр		30,282,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		30,282,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		(30,282,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	73,775,479.44	41,538,309.15
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		73,775,479.44
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	73,775,479.44	115,313,788.59

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,035,023.90	600,528,489.75	804,644,601.19	1,647,208,114.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(1,646,343,970.84)	(1,646,343,970.84)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	242,035,023.90	600,528,489.75	(841,699,369.65)	864,144.00
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн		(864,144.00)		(864,144.00)
Тайлант үеийн үр дүн			1,889,044,950.59	1,889,044,950.59
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,035,023.90	599,664,345.75	1,047,345,580.94	1,889,044,950.59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн	242,035,023.90	599,664,345.75	1,047,345,580.94	1,889,044,950.59
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			105,314,167.27	105,314,167.27
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,035,023.90	599,664,345.75	1,152,659,748.21	1,994,359,117.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		73,775,479.44	(73,775,479.44)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,135,099,700.00	978,460,488.85	156,639,211.15	86.2%
УРСГАЛ ЗАРДАЛ	1,135,099,700.00	978,460,488.85	156,639,211.15	86.2%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,079,342,000.00	922,398,048.39	156,943,951.61	85.5%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	704,687,800.00	618,667,424.02	86,020,375.98	87.8%
Үндсэн цалин	479,066,800.00	424,253,438.93	54,813,361.07	88.6%
Нэмэгдэл	197,739,000.00	169,821,102.67	27,917,897.33	85.9%
Урамшуулал	27,882,000.00	24,592,882.42	3,289,117.58	88.2%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	88,086,100.00	77,447,085.33	10,639,014.67	87.9%
Тэтгэврийн даатгал	59,898,700.00	53,187,980.06	6,710,719.94	88.8%
Тэтгэмжийн даатгал	7,046,900.00	6,182,766.35	864,133.65	87.7%
ҮОМШӨ-ний даатгал	5,637,500.00	4,908,973.23	728,526.77	87.1%
Ажилгүйдлийн даатгал	1,409,300.00	1,173,217.72	236,082.28	83.2%
Эрүүл мэндийн даатгал	14,093,700.00	11,994,147.97	2,099,552.03	85.1%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,234,500.00	180,773,671.54	11,460,828.46	94.0%
Гэрэл, цахилгаан	9,335,800.00	9,419,890.16	(84,090.16)	100.9%
Түлш, халаалт	182,648,700.00	170,682,781.38	11,965,918.62	93.4%
Цэвэр, бохир ус	250,000.00	671,000.00	(421,000.00)	268.4%
Норматив зардал	29,870,100.00	25,216,827.50	4,653,272.50	84.4%
Хоол, хүнс	29,870,100.00	25,216,827.50	4,653,272.50	84.4%
Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	999,590.00	410.00	100.0%
Урсгал засвар	1,000,000.00	999,590.00	410.00	100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	7,772,500.00	7,036,200.00	736,300.00	90.5%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	2,413,000.00	2,433,400.00	(20,400.00)	100.8%
Мэдээлэл технологийн зардал	5,359,500.00	4,602,800.00	756,700.00	85.9%
Бараа үйлчилгээний бусад зардал	55,691,000.00	12,257,250.00	43,433,750.00	22.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	47,651,800.00	4,237,050.00	43,414,750.00	8.9%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,039,200.00	8,020,200.00	19,000	99.8%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,757,700.00	56,062,440.46	(304,740.46)	100.5%
Бусад урсгал шилжүүлэг	55,757,700.00	44,601,202.00	11,156,498.00	80.0%

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төрөөс иргэдэд олгох тэтгэмж дэмжлэг	48,790,300.00	37,633,802.00	11,156,498.00	77.1%
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,967,400.00	6,967,400.00		100.0%
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		11,461,238.46	(11,461,238.46)	
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		11,461,238.46	(11,461,238.46)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,061,349,000.00	1,061,499,348.00	(150,348.00)	100.0%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	866,887,600.00	866,887,300.00	300.00	100.0%
Улсын төсвөөс санхүүжих	866,887,600.00	866,887,300.00	300.00	100.0%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	193,234,500.00	193,234,500.00		100.0%
Орон нутгийн төсвөөс	193,234,500.00	193,234,500.00		100.0%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,226,900.00	1,337,548.00	(150,648.00)	112.3%
Туслах үйл ажиллагааны орлогоос	1,226,900.00	1,377,548.00	(150,648.00)	112.3%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		73,775,479.44	(73,775,479.44)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		115,313,788.59	(115,313,788.59)	
АЖИЛЛАГСДЫН ТОО	39	37	2	94.9%
Удирдах ажилтан	1	1		100.0%
Гүйцэтгэх ажилтан	20	18	2	90.0%
Үйлчлэх ажилтан	18	18		100.0%

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	193,234,500.00	193,234,500.00		100.0%
УРСГАЛ ЗАРДАЛ	193,234,500.00	193,234,500.00		100.0%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	193,234,500.00	181,773,261.54	11,461,238.46	94.1%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,234,500.00	180,773,671.54	11,460,828.46	94.0%
Гэрэл, цахилгаан	9,335,800.00	9,419,890.16	(84,090.16)	100.9%:
Түлш, халаалт	182,648,700.00	170,682,781.38	11,965,918.62	93.4%
Цэвэр, бохир ус	250,000.00	671,000.00	(421,000.00)	268.4%
Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	999,590.00	410.00	100.0%
Урсгал засвар	1,000,000.00	999,590.00	410.00	100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		11,461,238.46	(11,461,238.46)	
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		11,461,238.46	(11,461,238.46)	
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		11,461,238.46	(11,461,238.46)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	193,234,500.00	193,234,500.00		100.0%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	193,234,500.00	193,234,500.00		100.0%
Орон нутгийн төсвөөс	193,234,500.00	193,234,500.00		100.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
АЖИЛЛАГСДЫН ТОО	39	37	2	94.9%
Удирдах ажилтан	1	1		100.0%
Гүйцэтгэх ажилтан	20	18	2	90.0%
Үйлчлэх ажилтан	18	18		100.0%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь эрхэм зорилгоо “Хүүхэд бүр тоглоомын орчинд өөртөө итгэлтэй, чөлөөтэй сэтгэн бодох, өөрийгөө илэрхийлэх, хүсэл сонирхолдоо хөтлөгдсөн, идэвхтэй суралцагч байхад нь үлгэрлэн дагуулж, хамтдаа хөгжих замаар хүүхэд бүрийг “Монгол хүн болгон төлөвшүүлнэ” гэж тодорхойлсон байна. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 14 зорилт, хэрэгжүүлэх 58 арга хэмжээтэй баталснаас нийт 85.2%-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хууль, Ерөнхий боловсролын тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (батлагдсан:2022-11-04 хэрэгжиж эхлэх:2023-03-01)
- Монгол улсын үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай
- Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2023 оны санхүүгийн хяналт, шалгалтын ажил хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/22 тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105,314.1 мянган төгрөгөөр букуу 5.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	73,775.5	115,313.8	41,538.3
Авлага	48.6		48.6
Бараа материал	42,181.7	46,992.2	4,810.5
Үндсэн хөрөнгө	1,773,039.2	1,832,053.1	59,013.9
Нийт хөрөнгө	1,889,045.0	1,994,359.1	105,314.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,889,045.0	1,994,359.1	105,314.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,889,045.0	1,994,359.1	105,314.1

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт орсон дараах данснууд байна. Үүнд: мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө тус бүр

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 41,538.3 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 4,810.5 мянган төгрөгөөр өссөн нь 3,548.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж 28,926.3 мянган төгрөг, тоног төхөөрөмж 76,714.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 6,026.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 30,282.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 122,133.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,994,359.1 мянган төгрөг болж 105,314.1 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 721,076.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 179,634.5 мянган төгрөг, нийт 900,711.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 159,410.8 мянган төгрөгөөр өсгөн, 1,061,349.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 159,410.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 866,887.3 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 193,234.5 мянган төгрөг, нийт 1,060,121.8 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 866,887.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 193,234.5 мянган төгрөг, нийт 1,060,121.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож 11,461.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 989,678.2 мянган төгрөг буюу 86.2 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	71802- Ерөнхий боловсрол				
1.1	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,143.8	2,143.8		100%
1.2	81806-Дотуур байр	53,857.1	43,958.6	9,898.5	70%
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	27,382.2	27,382.2		100%
1.4	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	4,823.5	4,823.5		100%
1.5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	639,314.1	566,660.2	72,653.9	89%
1.6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	155,900.6	130,947.7	24,952.9	84%
1.7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	192,234.5	180,773.7	11,460.8	94%
1,8	80312 сургалт семинар	1,071.9	1,071.9		100%
1,9	81801 үдийн цай хөтөлбөр	48,790.3	37,633.8	11,156.5	84%
1,10	81827 бичиг үсгийн боловсрол	4,024.9	4,024.9		100%
1,11	81844 гүнзгийрүүлсэн сургалт	150.7	150.7		100%
1,12	81848 түрээсийн ном	2,413.0	2,413.0		100%
	Дүн	1,135,099.7	1,008,539.4	130,119.6	86.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн нь Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 72,562.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Хүүхдийн хоол хүнс 62,850.6 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар, 9,711.4 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардал, бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, төлбөр хураамжийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 18,773.6 мянган төгрөгийн тогтмол зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 62,850.6 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн буурсан цэцэрлэгийн хүүхдийн тоо багассантай холбоотой 16,109.7 мянган төгрөгийн хоол, хүнсийг зарцуулаагүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн 4 зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, дараагийн шатны хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь батлагдсан 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 979,426.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 14,691.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,018.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын орон тоог хэмнэх, хавсран ажиллах, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээс батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант онд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 54,401.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 81.2 мянган төгрөг, норматив зардал 23,119.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэн ажилласан байна.

Судалгааны үр дүн, нөхцөл байдлын талаар бичих

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь бүртгэлд байгаа үндсэн хөрөнгө болон цалин хөлс, урамшуулал, байр ашиглалт, эрүүл мэндийг дэмжих, хүүхдийн хоол, багшийн мэргэжил дээшлүүлэх, цахим хэрэглээ, хэрэгжиж буй төсөл арга хэмжээтэй холбоотой 8 судалгааг ирүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 159 мэдээллээс 155 мэдээллийн хугацаандаа, 2 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийн хугацаа болоогүй хүлээгдэж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль 2023 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж, 3 албан шаардлага, 2 төлбөрийн акт өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 16 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	468.1	2	468.1	100%
Албан шаардлага	3	8,920.2	3	8,920.2	100%
Зөвлөмж	5	785,215.3	2	785,215.3	100%
Нийт дүн	10	794,603.6	10	794,603.6	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 124,741.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа.

1.Аудитаар Санхүү байдлын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан хоорондын уялдаа 124,741.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь, УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 5,219.4 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 4 зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Бараа материалтай тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэхийг хориглосон 4,300.1 мянган төгрөгийн хоол, хүнсний бүтээгдэхүүн авч хэрэглэсэн байна. Энэ нь УСНББОУС-ын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 5.20-д "Хуулиар хүлээсэн үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгждэг.Ийм хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг нь янз бүрийн хуулийн илэрхийлэх утгаас үүснэ", Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн хамтарсан А/448, А/268 дугаартай "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг батлах тухай" тушаалд заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлж хүүхдийн хоол хүнсэнд тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэх

2. ХХОАТ-ын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: ХХОАТ-ын тайлантай цалингийн хүснэгтийг тулган шалгахад 919.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь УСНББОУС-ын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 5.20-д "Хуулиар хүлээсэн үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгждэг.Ийм хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг нь янз бүрийн хуулийн илэрхийлэх утгаас үүснэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлж татварын тооцооллыг үнэн зөв хийж хэвших;

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.Газрын бүртгэлтэй тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэр дээр бүртгэлтэй 6420 м.кв газрыг үндсэн хөрөнгийн тайланд бүртгээгүй байна. Энэ нь УСНББОУС-ын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 5.20-д “Хуулиар хүлээсэн үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгждэг. Ийм хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг нь янз бүрийн хуулийн илэрхийлэх утгаас үүснэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль дүрэм журмыг хэрэгжүүлж газрыг бүртгэх зөвлөмж хүргүүлэх;

4.Хандив тусламжийн орлого бүртгэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд төгсөгчид болон иргэдээс авсан хандив тусламжаар үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа "Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сан"-ийн үлгэрчилсэн дүрмийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь УСНББОУС-9 стандартын 17-д "Тухайн орлогыг хүлээн авсан бараа, үйлчилгээний бодит үнэ цэнээр хэмжих ба шилжүүлсэн аливаа мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүнгээр тохируулна. Хүлээн авсан бараа, үйлчилгээний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй тохиолдолд орлогыг тухайн өгсөн бараа, үйлчилгээний бодит үнэ цэнээр орлогыг хэмжих ба шилжүүлсэн аливаа мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүнгээр тохируулна.", Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 Боловсролын санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагаас дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламж, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ; Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дугаар тушаалын 1.1 Өмчийн хэлбэр харгалзахгүй их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль /цаашид сургууль гэх/, цэцэрлэгт дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, сайн дурын байгууллагаас /цаашид хандивлагч болон тусламж үзүүлэгч гэх/ санаачлан сайн дурын үндсэн дээр тухайн байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулан өгсөн хандив, буцалтгүй тусламжийн орлогыг "Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сан"-д бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, мэдээ тайланд тусгах харилцааг энэхүү дүрмээр зохицуулна" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлж хандив тусламжийн орлогыг бүртгэж дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүү байдлын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан хоорондын уялдаа хангагдахгүй зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	124,741.7			1	124,741.7	1	124,741.7				
Дүн	1	124,741.7			1	124,741.7	1	124,741.7				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хориглосон хоол, хүнсний бүтээгдэхүүн хэрэглэсэн	1	4,300.1					1	4,300.1				
ХХОАТ-ын тайлангаас цалингийн хүснэгт зөрүүтэй	1	919.3					1	919.3				
Газрыг бүртгэж тайлагнаагүй	1	-					1	-				
Хандив тусламжийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлогодож, сан байгуулах	1	-					1	-				
Дүн	4	5,219.4					4	5,219.4				